



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 5 сарын 02 өдөр

Дугаар А/338

Есөнбулаг

Г Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын дүрэм, бүтэц орон тоог шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх "Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дүрэм"-ийг нэгдүгээр хавсралтаар, бүтэц орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Болдбаатар), дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)- тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дүрэм, бүтэц орон тоог батлах тухай аймгийн Засаг даргын 2023 оны А/73 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

شعبه - هیئت انتخابی
کلیه اعضا



شماره پرونده

شماره

شماره
شماره
شماره

شماره پرونده

هیئت انتخابی، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات

پس از آنکه هیئت انتخابی، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات
شماره پرونده ۹۹، شماره پرونده ۶۰۰، شماره پرونده ۱۰۹، شماره پرونده ۷۰۰، شماره پرونده ۶۰۰
هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات

۶. هیئت انتخابی، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات
شماره پرونده ۹۹، شماره پرونده ۶۰۰، شماره پرونده ۱۰۹، شماره پرونده ۷۰۰، شماره پرونده ۶۰۰
۷. هیئت انتخابی، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات
شماره پرونده ۹۹، شماره پرونده ۶۰۰، شماره پرونده ۱۰۹، شماره پرونده ۷۰۰، شماره پرونده ۶۰۰
هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات

۸. هیئت انتخابی، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات
شماره پرونده ۹۹، شماره پرونده ۶۰۰، شماره پرونده ۱۰۹، شماره پرونده ۷۰۰، شماره پرونده ۶۰۰
هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات، هیئت نظارت بر انتخابات



شماره پرونده

3200010518

Аймгийн Засаг даргын
2021 оны 05 сарын 01-ны өдрийн
48 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь /цаашид "газар" гэнэ/ Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий бүтэц, орон тоо, удирдлагын бүдүүвчийн дагуу байгуулагдсан газар нь аймгийн нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт шалгалт хийх, судалгаа шинжилгээ, сургалт сурталчилгаа зохион байгуулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар явуулж байгаа төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

2.Газрын үндсэн зорилго нь Байгаль орчны хууль тогтоомжийг нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэх, байгаль орчны салбарын байгууллагуудтай хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэх, мэргэжил, арга зүй удирдлагаар хангах, байгаль орчны судалгаа шинжилгээ, сургалт, сурталчилгааны ажлыг гүйцэтгэхэд оршино.

3.Газар нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын холбогдох агентлагууд, Иргэдийн төлөөлөгчийн хурал, Засаг даргын бодлого, тогтоол, шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгон тэднээс мэргэжил арга зүйн удирдамж авч байгаль орчны салбарын байгууллагууд болон олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай ажлын уялдааг хангаж ажиллана.

4.Газар нь аймгийн хэмжээний байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлыг арга зүйн удирдлагаар тогтмол хангаж, хэрэглэгчдийг байгаль орчны мэдээллээр хангах, экологийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

5.Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба төрийн сан банкинд харилцах данстай байна.

Хоёр. Газрын удирдлага, бүтэц

1.1. Аймгийн байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр аймгийн Засаг дарга томилно.

Газрын дарга дор дурдсан эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:

2.1.1 Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах

2.1.2 Газрын дотоод хэлтэсүүдийн үйл ажиллагааны чиглэл, албан тушаалын тодорхойлолт, хэлтсийн дарга нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, үр дүнг дүгнэх

2.1.3 Газрын албан хаагчдыг зохих журмын дагуу томилох, чөлөөлөх, шагнах, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлүүлэх

2.1.4 Батлагдсан төсвийг захиран зарцуулах.

2.1.5 Газрын нэрийн өмнөөс бусад байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах

2.1.6 Эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах

2.1.7 Газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргыг бүрэн хангах

2.1.8 Байгаль орчин, аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар Монгол улсын ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн хурал, Засаг даргын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх талаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах талаар аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнүүлэн ажиллана.

2.1.9 Байгаль орчин, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлттэй холбоотой ажлуудыг сум тус бүрээр ангилан Аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах гэрээнд тусгуулж сумын Засаг дарга нарт дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.

2.1.10 Газрын дотоод бүтэц болох Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн хэлтэс, Ой, аялал жуулчлал, захиргаа, аж ахуйн хэлтэсүүд ажиллуулах, сум дундын ойн ангийг харъяалан удирдах.

2.1.11 Газрын албан хаагчдын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, давтан сургах, дадлага туршлагажуулахад туслалцаа үзүүлэх

2.1.12 Байгаль орчныг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэнд мэргэжил арга зүйн болон бусад чиглэлээр дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах, хамтран ажиллах.

2.1.13 Байгаль орчны зарим тулгамдсан асуудал бүрээр хөтөлбөр санаачлан боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангуулах

2.1.14 Сумдын байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагчийг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу томилох, чөлөөлөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах

2.1.15 Байгаль орчны салбарын байгууллагуудын хамтын уялдаа холбоог хангуулах зорилгоор газрын даргад зөвлөх эрх бүхий зөвлөлийг ажиллуулах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүнд газрын Хэлтсийн дарга нар, Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга нар, Усны сав газрын дарга, Ус, цаг-уур орчны шинжилгээний төвийн дарга, Сум дундын ойн ангийн дарга, газрын ахлах мэргэжилтэнгүүд, аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн байгаль орчин, аялал жуулчлал хариуцсан мэргэжилтнийг тус тус оруулна. Зөвлөлийг газрын дарга удирдаж бүрэлдэхүүнийг өөрийн тушаалаар томилно.

2.1.16 Газрын өдөр тутмын үйл ажиллагааг хангах газрын даргын дэргэдэх зөвлөлийг байгуулах бөгөөд бүрэлдэхүүнд Хэлтсийн дарга нар, Ахлах мэргэжилтэнгүүд, Нягтлан бодогч гэсэн бүрэлдэхүүнтэй байна. Зөвлөлийг газрын дарга өөрөө удирдаж бүрэлдэхүүнийг өөрийн тушаалаар томилно.

Гурав. Газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.1. Шинэ сэргэлтийн бодлого, "Алсын хараа 2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Байгаль орчин, аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурал, Засгийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын шийдвэрээр батлагдсан байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, "Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг хөгжүүлэх үндсэн чиглэл, Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогын баримт бичиг болон бусад баримт бичгүүдэд байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах

3.2. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын дүрэм журам стандартуудыг мөрдүүлэх, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих

3.3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах.

3.4. Орон нутагт байгаль хамгаалах чиглэлээр хэрэгжиж байгаа гадаадын болон дотоодын төсөл хөтөлбөрүүдийн хөрөнгө оруулалтыг бүрэн дүүрэн татаж, үр дүнтэй ажил зохион байгуулах.

3.5. Аймгийн Засаг даргатай Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын байгуулсан хамтран ажиллах гэрээнд тусгагдсан тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах

3.6. Сумдын хэмжээнд хэрэгжүүлэх байгаль орчны арга хэмжээг жил, улирлаар төлөвлөн зохион байгуулж дүгнэх

3.7. Байгаль хамгаалагчдыг сонгох, мэргэжлийн удирдлагаар байнга хангаж, тэдний үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, шагнаж уурамшуулах.

3.8. Газрын албан хаагчид болон байгаль хамгаалагчдыг дөрвөн улиралын хувцас болон хяналт шалгалт судалгаа шинжилгээ хийхэд шаардагдах багаж хэрэгсэл, унаагаар хангах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх

3.9. Байгалийн болон аялал жуулчлалын нөөц баялгийн талаарх мэдээллийн сангийн үйл ажиллагааг эрхлэн, холбогдох байгууллага, иргэдэд байгаль орчны мэдээллээр үйлчлэх

3.10. "Байгаль орчныг хамгаалах тухай" хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 37 дугаар зүйлийн 37.1 дэх заалтуудыг жишиг болгон байгаль орчны мэдээллийн улсын сангийн мэдээ, баримтыг бүрдүүлэн байгаль орчин аялал жуулчлалын яаманд хуулийн хугацаанд хүргүүлж байх

3.11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийг ханган, төслүүдийг үнэлгээнд бүрэн хамруулах, аж ахуйн нэгж байгууллагуудын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хуулийн дагуу эрх үүргийнхээ хүрээнд гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтийн талаархи тайланг жил бүр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлж байх

3.12. Иргэдийг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зорилгоор ногоон орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Энэ ажилд байгууллага, иргэдийн хүч оролцоо, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах

3.13. Нутгийн ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Байгаль орчныг хамгаалах болон аялал жуулчлалын тухай хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулан мэргэжлийн ажилчдыг сургах, давтан сургах боловсон хүчний мэдлэг боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх.

3.14. Ой, ус, ургамал, ан амьтан зэрэг, байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад зориулсан хялбарчилсан гарын авлага, зөвлөмж боловсруулан нийтийн хүртээл болгох.

3.15. Байгаль орчныг хамгаалах ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог өргөжүүлж, тэдний санал хүсэлт, мэдээллийг хүлээн авч хэрэгжүүлэх арга хэмжээг авах.

3.16. Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг бүрдүүлэх, түүнд холбогдох талуудын оролцоог хангах ажлыг зохион байгуулах.

3.17. Байгаль орчин, аялал жуулчлалын холбогдолтой судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулж гүйцэтгүүлэх, үр дүнг хүлээн авах

3.18. Аймгийн нутаг дэвсгэрт байгаа ой, ус, ургамал, ан амьтан зэрэг байгалийн нөөц баялаг, түүнээс ашиглаж болох тоо хэмжээг нарийвчлан тогтоолгох, тэдгээрийг мөрдүүлж ажиллах

3.19. Ой, ус, ургамал, амьтан зэрэг байгалийн баялгийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх, улсын захилгат, даалгаварт ажлын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, агаар, ус, хөрсийг бохирдлоос хамгаалах, хяналт шинжилгээ хийх асуудлыг хариуцан зохион байгуулах, энэ ажилд ус цаг уур орчны шинжилгээний албыг татан оролцуулах, хог хаягдал, химийн бодисын менежментийг хэрэгжүүлэх, ой хээрийн түймрээс сэргийлэх ажлыг зохион байгуулах, экосистемд учирсан хохирлын талаар мэргэжлийн дүгнэлт гаргах, хохирлыг нөхөн төлүүлэх талаар хууль хяналтын байгууллагад хандах

3.20. Байгаль орчныг доройтлоос хамгаалах, нөхөн сэргээх, үүний дотор ойжуулах, ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх, халгүй хаягдалгүй технологи нэвтрүүлэх арга хэмжээг зохион байгуулах, тухайн аймагт энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэд болон ой, ус, ургамал, ангийн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах

3.21. Тусгай хамгаалалттай газар нутгийг өргөтгөх, ангилал дээшлүүлэх ажлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллах.

3.22. Аймгийн усны нөөц, түүнийг зохистой ашиглах, хэрэглээний байдлыг үнэлэх, усны тооллого судалгааг хийх, сөрөг нөлөөлөлд өртөж байгаа гадаргын усыг хамгаалах, хамгаалсан булгуудад орон нутгийн хэмжээнд мэдээллийн сан үүсгэх, булгуудыг гэрчилгээжүүлэх.

3.23. Байгаль орчны хууль бус үйл ажиллагаанд хяналт шалгалтыг тогтмол хийх.

- Усны нөөц, ашиглалт хамгаалалт, төрийн бус байгууллага хариуцсан ахлах мэргэжилтэн-1
- Амьтны асуудал, статистик мэдээллийн сан, мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтэн-1
- Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн-1
- Орчны бохирдол, хог хаягдал, химийн бодис хариуцсан
- Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, сургалт сурталчилгаа, гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн-1
- Байгаль орчны хяналтын улсын байцаагч-2
- Байгаль хамгаалагчид-26

Хуралган буй орчин, байгалийн нөөцийн хэлтсийн дарга-1

- Тусгай хамгаалалттай газар, Хүний нөөц бодлого төлөвлөлт, хариуцсан ахлах мэргэжилтэн-1
- Шийдвэрийн биелэлт, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн-
- Ой, ургамал, байгалийн гамшгийн асуудал хариуцсан
- Аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн-1
- Нягтлан бодогч-1
- Архив бичиг хэргийн эрхлэгч-1
- Нярав-1
- Жолооч-1
- Үйлчлэгч-1
- Харуул-4

Ой, аялал жуулчлал, захиргаа аж ахуйн хэлтсийн дарга-1

ДАРГА-1

1998 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт
 2004 оны 05 сарын 19-ны өдрийн
 Аймгийн Засаг даргын